



ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ
УХААНЫ ИХ СУРГУУЛЬД

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.17 № 02/10 ҮАГ-САГ/2014/10/СТА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай


ЭМШУИС-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд аудит хийх явцад тус байгууллага нь багш ажилтнуудад олгож буй нэмэгдэл цалин хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулаагүй зөрчил илэрлээ.

1. Хичээл нөхөлтийн олговор, дагалдан сургасны хөлс, үзлэгийн орлогоос хувь тооцож олгосон нэмэгдэл, цагийн хөлс гэх мэт багш ажилтнуудад олгож буй хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод оногдох **33,770,9** мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг оногдуулж, төлөөгүй байна. Энэ нь "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17 дугаар зүйл 17.1.1-д заасан "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх үүрэгтэй" заалтыг зөрчсөн байна. /тооцоо хавсралт № 1/
2. Санхүүгийн тооцоолох програмдаа өөрчлөлт хийгээгүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу тооцоолсон нийт **212.4** мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь 2012 оны 10-р сарын 25-ны өдрийн нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1-д заасан "Ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ "0.5" гэснийг тус бүр "0.8" гэж, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ "0.5" гэснийг тус бүр "0.2" гэж тус тус өөрчилсүгэй" заалтыг зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийн боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-ыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, нийгмийн даатгалын шимтгэл оногдуулаагүй 33,983.3 мянган төгрөгийн зөрчлийг бүрэн арилгаж, хариуг албан ёсоор 2014 оны 06-р сарын 30-ны дотор ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн захирал Г.Батбаатар, Санхүү эдийн засгийн газрын дарга Р.Дашжав нараас шаардаж байна.

ШИНЖЭЭЧ



Н.НЯМДАВАА